



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2018 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 4/52

Улаанбаатар хот

**“ШУТИС-ийн дэргэд гарааны компани
байгуулж, ажиллуулах журам” батлах тухай**


“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.14.7 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн дэргэд гарааны компани байгуулж, ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталж, 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-34 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “ШУТИС-ийн дэргэд инновацийн гарааны компани, ШУТИС-ийн хөрөнгө оруулалттай компани байгуулж ажиллуулах түр журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Намнан/, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвүүдийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ДЭРГЭД ГАРААНЫ КОМПАНИ БАЙГУУЛЖ, АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл


1 дүгээр зүйл. Журмын зорилго, хамрах хүрээ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь ШУТИС-ийн дэргэд гарааны компани байгуулах үндсэн зарчмыг тогтоох, үйл ажиллагаа эрхлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 “ШУТИС-ийн дэргэд гарааны компани байгуулж, ажиллуулах журам” /цаашид “Журам” гэх/ нь Монгол улсын Инновацийн тухай хууль, Компанийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, ШУТИС-ийн оюуны өмчийн бодлого, Технологи дамжуулах журам болон бусад холбогдох дүрэм, журмаар зохицуулагдана.
- 1.3 Энэхүү журам нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэн, төв, нэгж, тэдгээрийн судлаачдын дангаараа болон бусадтай хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр бүтээсэн, илүү боловсронгуй болгосон, сайжруулан хөгжүүлсэн гэх мэт судалгаа боловсруулалт, инновацийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон “оюуны бүтээл”-ийг бүтээгдэхүүн, технологид хувиргах, нэвтрүүлэх, зах зээлд гаргах үйл ажиллагааны хүрээнд үйлчилнэ.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 “Шинжлэх Ухаан, Технологийн Их сургууль” гэж ШУТИС, түүний бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэн, төв, бусад нэгжүүдийг ойлгоно.
 - 2.1.2 “Судлаач” гэж ШУТИС-ийн профессор, багш, ажилтан, суралцагчдыг;
 - 2.1.3 “Оюуны бүтээл” гэж Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн эсвэл эрхийн хамгаалалт хийлгэхээр мэдүүлсэн бүтээлийг;
 - 2.1.4 “Инновацийн үйл ажиллагаа” гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн (тасралтгүй үргэлжлэх цогц) арга хэмжээг;
 - 2.1.5 “Их сургуулийн дэргэдэх Гарааны компани” гэж бизнесийн өсөлтийг бий болгох чадвартай инновацийн төсөл хэрэгжүүлэхээр ШУТИС дангаараа болон судлаачид, гадаад дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран Компанийн тухай хуулийн 3.5-д заасан хэлбэрээр байгуулсан компанийг;
 - 2.1.6 “Лицензийн гэрээ” гэж оюуны бүтээлийг ашиглах эрх олгох эсвэл олж авах гэрээг;

- 2.1.7 “Роялти” гэж оюуны бүтээлийг лицензийн гэрээгээр ашигласны төлбөрт лиценз өгөгчид ноогдох хэмжээг тооцох хувь хэмжээг;
- 2.1.8 “Төсөл” гэж инновацийн тухай хуулийн 3.1.6-д заасан Инновацийн төслийг;
- 2.1.9 “Хөрөнгө оруулагч” гэж инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэгч хувь хүн, хуулийн этгээдийг тус тус ойлгоно.



Хоёр. Гарааны компани байгуулах

3 дугаар зүйл. Гарааны компани байгуулах хүсэлт гаргах, дүгнэх

- 3.1 Сонирхогч этгээд ШУТИС-ийн Технологи дамжуулах журмын 12.3 дугаар зүйлд заасны дагуу лицензийн гэрээ хийгдсэн оюуны бүтээлийг гарааны компани байгуулах хүсэлтээ ШУТИС-ийн Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 3.2 Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж гарааны компани байгуулах хүсэлтийг хүлээн авч, бүртгүүлсэн судлаачдын оюуны бүтээлийг гарааны бизнес болгон хөгжүүлэх эсэх талаар холбогдох ажлын хэсэг томилж, дүгнэлт гаргуулна.
- 3.3 Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгжээс томилогдсон ажлын хэсэг нь салбар бүрийн мэргэшсэн хүмүүсээс бүрдэх ба техник технологийн шинжилгээ, зах зээлийн хэрэгцээ, бизнесийн боломж, хөрөнгө оруулалтын өгөөж болон эдгээрт хамаарах шалгуураар үнэлж, түүнд үндэслэсэн дүгнэлтийг хүсэлт гаргасан өдрөөс хойш 3 сарын дотор гаргана.

4 дүгээр зүйл. Гарааны компани байгуулах төсөл боловсруулах

- 4.1 Энэхүү журмын 3.3 дугаар зүйлд заасан дүгнэлтээр дэмжигдсэн оюуны бүтээлийг цаашид судлах, төсөл боловсруулах, хөгжүүлэх ажлыг Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж төсөл санаачлагчтай хамтран гүйцэтгэнэ.
- 4.2 Энэ журмын 4.1 дүгээр зүйлд тусгагдсан асуудлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх ажлыг ШУТИС-ийн холбогдох нэгж, багш эрдэмтэдтэй гэрээ байгуулж, төсөв зардлыг ШУТИС болон судлаачийн өөрийн эх үүсвэрээс гаргахыг Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж хариуцан шийдвэрлүүлнэ.
- 4.3 ШУТИС-ийг түшиглэн гарааны бизнесийг хөгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий инновацийн дэд бүтцийн нэгжүүдийг технологи-бизнесийн болон бизнес инкубаторын хэлбэрээр байгуулж ажиллуулж болно.
- 4.4 Энэ журмын 4.3-д заасан нэгжүүд нь гарааны компанид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, бойжуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллана.

5 дугаар зүйл. Төсөл бүртгүүлэх

- 5.1 Гарааны компани байгуулах хүсэлтэй судлаачийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна.
- 5.1.1 Гарааны компани байгуулах оюуны бүтээлийн эрх эзэмшигч нь эсвэл лиценз эзэмшигч нь ШУТИС байх;
- 5.1.2 Оюуны бүтээлийн эрх эзэмшигч (гадаад, дотоодын) гуравдагч этгээд нь ШУТИС-тай лицензийн гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллах;

- 5.1.3 “Инновацийн тухай хууль”-ийн 14.1-д заасан шаардлагуудыг хангасан байх;
- 5.1.4 Төсөл хэрэгжүүлэх хүний нөөц бүрдүүлсэн байх;
- 5.1.5 Гарааны компани байгуулах үндэслэл, үйл ажиллагааны чиглэл, зорилго, инновацийн бүтээгдэхүүний ач холбогдол, зах зээлийн судалгаа, техник-эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцооллын талаар танилцуулга бүхий “Төсөл” бичсэн байх;
- 5.2 Төсөл санаачлагч нь энэхүү журмын 5.1 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл доорх материалыг бүрдүүлэн, их сургуулийн дэргэдэх гарааны компани байгуулах тухай хүсэлтээ Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгжид бичгээр гаргана.
- 5.2.1 Гарааны компани байгуулах тухай хүсэлт;
- 5.2.2 Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн эсвэл хийлгэхээр мэдүүлснийг нотлох баримт;
- 5.2.3 Төсөл (2 хувь);
- 5.3 Гарааны компани байгуулах хүсэлт гаргасан төслүүдийг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Тус дэд зөвлөл нь гарааны компани байгуулах төслийг сонгохдоо Инновацийн тухай хуулийн 14.1 дэх заалт болон 15 дугаар зүйлийг удирдлага болгоно.
- 5.4 ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр дэмжигдсэн төслийг Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж хариуцаж инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 5.5 Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж нь Инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тухайн төсөл сонгогдсон эсэх шийдвэрийг төсөл санаачлагчид бичгээр мэдэгдэнэ.

6 дүгээр зүйл. Гарааны компани байгуулах

- 6.1 Инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу гарааны компани байгуулахад ШУТИС дараах хэлбэрүүдээр оролцоно.
- 6.1.1 Боловсролын тухай хуулиар ШУТИС нь компанийн дүрмийн санд мөнгөн хөрөнгөөр хувь оруулах, хувьцаа худалдан авах боломжгүй тул бусад хэлбэрээр хувь нийлүүлнэ. Тухайлбал:
- Гарааны компанийг зах зээлд үйл ажиллагаа эрхэлж эхлэх хүртэл төсөл хэлбэрээр ШУТИС-иас дэмжлэг үзүүлэх;
 - Гарааны компанийг үйл ажиллагаа явуулах, хөгжүүлэхэд оюуны болон материаллаг туслалцаа үзүүлэх;
 - ШУТИС болон судлаачид нь өөрийн эзэмшлийн оюуны бүтээлийг эсвэл үүнээс үүсэх өмчийн эрхийг үүсгэн байгуулагчидтай тохиролцож эсвэл эрх бүхий байгууллагаар үнэлүүлэн компаний дүрмийн санд хувь нийлүүлэх;
- 6.1.2 ШУТИС гарааны компанийн дүрмийн санд хувь нийлүүлээгүй бол хувьцаа худалдан авах давуу эрхийн талаар хамтран ажиллах гэрээнд тусгах;
- 6.1.3 Компанийн дүрмийн санд хувь нийлүүлэхгүйгээр технологийн ба техникийн баримт бичгийн үнэ, Роялти авах зарчмыг зөвхөн лицензийн гэрээгээр зохицуулан хамтран ажиллах;

- 6.1.4 ШУТИС нь өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан компанид ноогдох хувьцаагаа эзэмших.
- 6.2 Гарааны компани нь Компанийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлд заасан хэлбэртэй байна. Компани үүсгэн байгуулах талаар ШУТИС болон судлаач, хөрөнгө оруулагч талууд хамтран ажиллах болон лицензийн гэрээ заавал байгуулна. Уг гэрээнд компанийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан асуудлуудыг тусгана.
- 6.3 Гэрээ байгуулсан талууд гарааны компани үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах ба үүсгэн байгуулагч бүр саналын тэнцүү эрхтэй оролцож шийдвэр гаргана. Хурлаар компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд тусгагдсан асуудлуудыг хэлэлцэж батална.
- 6.4 Гарааны компанид ШУТИС-ийг төлөөлөх эрх бүхий этгээд нь ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал хариуцсан албан тушаалтан байна.
- 6.5 Гарааны компанийн үүсгэн байгуулагч нартай хийсэн хамтран ажиллах болон лицензийн гэрээ, энэхүү журмын 3.3 дугаар заалтад дурьдсан дүгнэлтийг ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж компани байгуулах асуудлыг Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 6.6 Гарааны компанийг хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлыг ШУТИС-ийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэн Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж зохион байгуулж бүртгүүлнэ.
- 6.7 Байгуулагдсан гарааны компанийг Инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, Инновацийн тухай хуулийн 17-р зүйлд заасан хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэг авах асуудлыг Технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж удирдан гүйцэтгэнэ.

Гурав. Гарааны компанийн зохион байгуулалт, үйл ажиллагаа

7 дугаар зүйл. Гарааны компанийн үйл ажиллагаа

- 7.1 Тухайн гарааны компанийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, зохион байгуулалтын бүтэц нь компанийн тухай хуулиар зохицуулагдах ба уг журмын 6.2 дугаар зүйлд заасан гэрээнд энэ талаар нарийвчлан тусгана.
- 7.2 Гарааны компани нь өөрийн эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогийг тусгасан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх компанийн дотоод журамтай байх ба журмыг Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулна.
- 7.3 Гарааны компани нь дараах эрхийг эдэлнэ.
- 7.3.1 Гарааны компани нь Инновацийн тухай хуульд тодорхойлсон үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх;
- 7.3.2 Үйлдвэрлэсэн туршилтын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд сурталчлах, худалдан борлуулах;
- 7.3.3 Энэхүү журамд тодорхойлсон үндсэн үйл ажиллагаандаа зайлшгүй шаардлагатай санхүүгийн болон Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан төрийн аливаа хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг авах;
- 7.3.4 Гарааны компани нь үйл ажиллагаандаа ШУТИС-ийн нэр, логог ашиглах;
- 7.3.5 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс хөрөнгө бүрдүүлэх.
- 7.4 Гарааны компанийн санхүүжилт нь Инновацийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.



- 7.5 Гарааны компани нь дараах үүргийг хүлээнэ.
- 7.5.1 Гарааны компани нь Инновацийн тухай хуульд тодорхойлж, шинжээчдийн багийн дүгнэлт гаргуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэх бөгөөд компанийн дүрмээр тодорхойлсон үйл ажиллагаа явуулах;
 - 7.5.2 Компани нь дотоод, гадаадын байгууллагатай байгуулсан гэрээ, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх;
 - 7.5.3 Гарааны компани нь тухайн онд гүйцэтгэх ажил, үйлдвэрлэл, борлуулах бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажиллах;
 - 7.5.4 Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагад мөрддөг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норматив, стандартыг компани өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;
 - 7.5.5 Гарааны компани нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас гарч болох санхүүгийн болон эд материалын бусад эрсдлийг хувьцаа эзэмшигчдийн өмнө бүрэн хариуцаж ажиллах;
 - 7.5.6 Техник, технологийн нууц, ноу-хауг бусдад задруулахгүй байх;
 - 7.5.7 Компанийн орлогоос бий болсон ашгийн ноогдол хэсгийг лицензийн гэрээ болон компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчид, оюуны өмчийн эрх эзэмшигчид, зохиогчид/зохион бүтээгчдэд олгож байх;
 - 7.5.8 Гарааны компанийн ШУТИС-д ноогдох ноогдол ашигтай холбогдох асуудлыг гэрээгээр зохицуулах ба ноогдол ашгийг их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулна.
 - 7.5.9 Компани нь улирал, жилийн санхүүгийн тайлан, инновацийн мэдээг зохих журмын дагуу гаргаж ШУТИС-ийн Санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж болон бусад холбогдох байгууллагуудад хугацаанд нь тайлагнах;
- 7.6 ШУТИС-ийн Санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан албан тушаалтан гарааны компанийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаатай танилцах, хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.
- 7.7 Компанийн зохион байгуулалтын бусад асуудлыг компанийн тухай хууль, компанийн дүрэм болон байгууллагын дотоод журмаар зохицуулна.

8 дугаар зүйл. Гарааны компанийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах

- 8.1 Гарааны компанийг компанийн тухай хуульд заасны дагуу татан буулгаж, өөрчлөн зохион байгуулахаас гадна хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тохиолдолд үйл ажиллагааг зогсоох, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, худалдах шийдвэр гаргана. Үүнд:
- 8.1.1 Байгуулагдсанаас хойш 1 жилийн хугацаанд инновацийн туршилтын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй, эрхлэх боломжгүй нь тогтоогдсон;
 - 8.1.2 Компанийн тухай хууль, Инновацийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг дагаж мөрдөж ажиллаагүй;
 - 8.1.3 Компанийн дүрэмд зааж тодорхойлсон үндсэн үйл ажиллагаагаа бүрэн гүйцэтгэж дуусгаад өөрчлөн зохион байгуулах шаардлагатай болсон тухай дүгнэлтийг компанийн хувьцаа эзэмшигчид гаргасан;
 - 8.1.4 Санхүүгийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.

ШУТИС-ийн Захирлын 2018 оны 3 дугаар сарын
19. – ний өдрийн 1/52 тоот тушаалын хавсралт

- 8.2 Татан буулгах, өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарсан тохиолдолд компанийн тухай хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасны дагуу өр төлбөрийг барагдуулах, эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах, татан буугдсан тухай мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 8.3 Гарааны компанийг худалдан борлуулах тохиолдолд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах болон лицензийн гэрээнд заасны дагуу оногдох хөрөнгийг үүсгэн байгуулагчид олгоно.

9 дүгээр зүйл. Бусад

- 9.1 Компанийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрч чадахгүй тохиолдолд Монгол улсын Компанийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Компанийн дүрэм, тус улсад мөрдөгдөж байгаа бусад холбогдох хууль, тогтоомж, үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах болон лицензийн гэрээг үндэслэн шийдвэрлэнэ.
- 9.2 Гарааны компанийн үйл ажиллагааны мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуульд заасны дагуу зохицуулна.
- 9.3 Мэдээллийн нууцыг хадгалах, хууль бус эзэмшлээс сэргийлэх, задруулахтай холбоотой хариуцлагын талаарх эрх, үүргийг гарааны компанийн үүсгэн байгуулагч талууд гэрээгээр нарийвчлан тогтооно.
- 9.4 Гарааны компанид учирч болзошгүй эрсдлийг үүсгэн байгуулагчид, хөрөнгө оруулагч талууд компанийн дүрмийн санд оруулсан хөрөнгийн хувь хэмжээгээр болон гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хариуцна.

ooo O ooo